



## Говьсүмбэр аймгийн 3 дугаар цэцэрлэгийн ЗАН- World's largest lesson

Тус цэцэрлэгийн ЗАН-ээс 4-5 насны хүүхдүүдийн дунд зохион байгуулах “Бяцхан аврагчид” төсөлт тоглоомын явцад зохион байгуулах үйл ажиллагаанаас эхлэл төгсгөлийн холбоо хамаарал бүхий 2 үйл ажиллагааг сонгон энэхүү World's largest lesson-д илгээж байна. Энэхүү төсөлт тоглоом 40 хоногийн туршид үргэлжлэх юм. Төсөлт тоглоом хэрэгжих явцад хийгдэх ажлуудыг товчхон дурдсан болно.

### Үйл ажиллагаа 1

Сэдэв: Бяцхан аврагчид

Үйл ажиллагааны хэлбэр: Комик /сургамжит өгүүллэг/

Үйл ажиллагааны арга зүй: Бага насны хүүхдийг бүтээлчээр хөгжүүлэх арга зүй

Зорилго: Эх нутгаа хайрлан хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх аргыг мэдэх

Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалахад оролцоход суралцах

Өөрийн ойлгосныг үгээр болон жүжиглэлтээрээ бусдын хамт илэрхийлэх

Насны ангилал: 4-5 нас

Хүрэх үр дүн: Тогтвортой хөгжлийн зорилгыг ойлгоход дэмжлэг үзүүлнэ

Уран зохиолтой танилцах явцад хүрээлэн байгаа байгаль орчны байдалд дүн шинжилгээ хийх

Хуурай газрын эко системийг хамгаалан үүссэн асуудлыг шийдвэрлэхэд оролцох

Байгалиа хайрлах, мод тарьж ургуулах аргад суралцан өөрийн хувь нэмрийг оруулах хүсэл эрмэлзэлийг бий болгох



Бэлтгэл хэрэглэгдэхүүн: хэвлэмэл том ном, видео бичлэг, салхи шуурганы аудио бичлэг, аав ээжийн том цамцнууд, цаасан байшин

Хугацаа: 30 минут

Алхам 1. Эхийг сонсон , асуудлыг тодорхойлох

Алхам 2.Манай нутагт болдог шороон шуурганы тухай бичлэг, зураг үзэн эх зохиолд өгүүлэгдсэн байдалтай харьцуулах

Мөн шороон шуурганы үед та нарт юу гэж бодогдож байсан бэ?, хүүхдүүд ямар байдалтай байсан тухай ярилцана. Бид юу хийх ёстой вэ? Асуултыг хариултыг хамтдаа олох



Алхам 3. Эхийн дагуу жүжигчлэн тоглох, бид бас аврагчид болж чадах уу? Асуудлыг шийдвэрлэх

Хүүхдүүдээ бүгдээрээ “Бяцхан аврагчид “ зохиолынхоо тухай нэг ярилцъя.

Зохиолд хэн хэн гарч байна вэ?

Юуны тухай өгүүлж байна вэ?

Яагаад шороон шуурга болсон бэ?

Хүүхдүүд яагаад айсан бэ?

Та нар шороон шуурга болбол айх уу

Хүүхдүүд эцэг эхийн авчирч өгсөн том цамцыг өмсөн шуурга болж, зарим өгүүллэгийн гол дүрүүдийг жүжигчлэн тоглоно. Тоглолтонд багш аудио бичлэг ашиглана. Тоглох явцад багш , туслах багш нар дэмжин туслана.

Тоглосны дараа багш хүүхдүүдээ та нар бас аврагчид болмоор байна уу хэмээн асууна.

**ТИЙМЭЭ БҮГДЭЭРЭЭ БАС БЯЦХАН АВРАГЧИД БОЛЖ ШИВЭЭГОВЬ СУМАНДАА МОД ТАРЬЖ, УРГУУЛАН АВАРЦГААЯ.**

Ингээд ” **Бяцхан аврагчид төсөлт тоглоом**” төсөлт тоглоом хэрэгжүүлцгээе хүүхдүүдээ.

Эцэг эх, асран хамгаалагчдад: бүлгийн цахим хуудсаар дамжуулан тухайн эх зохиол болон видео бичлэгийг түгээнэ. Мөн төсөлт тоглоомын хэрэгжүүлэх төлөвлөгөөг илгээнэ. Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамтран манай суманд тарьж ургуулж болохуйц модыг судлана.

## Төсөлт тоглоом хэрэгжих явцад хийгдэх ажлууд

- Мод ургах үйл явцыг харуулсан бичлэг үзүүлнэ
- Модны ач тус, бидний амьсаглаж байгаа агаарыг цэвэршүүлж байгаа бичлэг үзүүлэн ярилцана.
- Улирал цаг агаарын онцлогоос хамааран модонд гарч байгаа өөрчлөлтийг бичлэг харуулан ярилцана.
- Сэдэвтэй холбоотой дуу, шүлэг, бүжиг сурцгаана, зүйр цэцэг үгс, оньсого зохионо.
- “Бяцхан аврагчид” ногоон байгууламж байгуулахад хийх ажлын жагсаалтыг нарийвчлан гаргана.
- Говийн бүсэд ямар ямар мод суулгавал ургах талаар судална, ярилцана.
- Тарих модоо сонгоно Өөрсдийн сонирхолоор сонгож авсан модны нэрээр хамтран баг болно.
- Сонгосон модны тухай судланаа, бусадтай мэдлэгээ хуваалцана, бүтээл хийнэ.
- Багаараа тухайн модоо яаж үрслүүлэн тарихыг судална
- Мод үрсэлгээ, суулгацыг бэлддэг газар байдгыг мэднэ
- эцэг эхчүүд хамтран тарих суулгацыг цуглуулна. Мод тарих нүх бэлдэнэ.

### Үйл ажиллагаа 2

Сэдэв Бяцхан аврагчид

Сургалтын хэлбэр- экскурс хичээл

насны ангилал 4-6

Зорилго:- Төсөлт тоглоом хэрэгжих явцад өөрсдийн бүтээсэн мэдлэг дээр тулгуурлан бүтээлч үйлээрээ хөгжих

Асуудлыг бүтээлчээрээ шийдвэрлэхэд оролцоход суралцах

Өөрсдийн хийсэн сайн үйлээрээ бахархах-бусадтай хамтран хөдөлмөр хийх

Хүрэх үр дүн: Тогтвортой хөгжлийн зорилгыг ойлгоход дэмжлэг үзүүлнэ

Хуурай газрын эко системийг хамгаалан үүссэн асуудлыг шийдвэрлэхэд оролцох

Байгалиа хайрлах, мод тарьж ургуулах аргад суралцан өөрийн хувь нэмрийг аав, ээж, ангийн хүүхдүүдийн хамт оруулах



Бэлтгэх хэрэглэгдэхүүн: ээж, аавуудын мод суулгахад зориулан ухсан нүх, бэлтгэсэн хөрс, усны сав, бордоо, бээлий, модны суулгац, хүрз

Заах арга:

- Туршилт хийх
- Асуулт дэвшүүлэх
- Харилцан ярилцах
- Тайлбарлах
- Практик үйл
- Бие даасан үйл ажиллагаа

**Алхам 1.** Бяцхан аврагчид гэж хэн бэ, яагаад мод мод тарих ётой вэ?, асуудал дэвшүүлэх

Хүүхдүүдээ бид энд яах гэж ирсэн билээ. Яагаад мод тарих ёстой вэ? хүүхдүүдтэй ярилцана.

-Хүүхдүүд яагаад гэвэл “Бяцхан аврагчид” шиг зүйлс бидэнд бас тохиолдсон тийм учраас мод манай суманд маш хэрэгтэй.

- За тэгвэл бүгдээрээ мод тарьж бяцхан аврагчид болох уу? Та нар юу гэж бодож байна.


Бидэнд туслахаар хүүхдүүд та нарын ээж, аав нь иржээ.

**Алхам 2.** Мод яаж тарьдаг вэ, өөрсдийн бүтээсэн мэдлэгээ бусадтайгаа хуваалцана.

Багш хүүхдүүдэд модыг хэрхэн суулгах талаар тайлбарлан харилцан ярилцана. Баг багаараа судласан сонгосон модоо тарина.

Хүүхдүүд ээж аавдаа туслаж хэрхэн модоо суулгах тухай ярилцана.

- Хүүхдүүд модны суулгац, бээлий , хүрз г.м зүйлсийг нэрлэнэ хэлнэ.



Алхам 3. Мод тарих , услах , асуудал шийдвэрлэх- Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал

Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамтран модны нүхыг ухаж бэлтгэсэн байна. Эцэг эхчүүд шороог хийн өгнө, хүүхдүүд суулгацаа барьж суулгахад туслана, услана. Энэ явцад мэдлэгээ батагана, бусадтай хуваалцана.

Бусадтай хамтран хөдөлмөр хийх

- Бид нар сая юу хийж дууссан бэ?

Яагаад мод тарьсан тухай харилцан ярилцана.

Хийсэн хөдөлмөрийн багаж хэрэгслээ хураана

Бид хэн билээ?

### ТИЙМЭЭ БИД “БЯЦХАН АВРАГЧИД”

Жил бүр сумынхаа бүх иргэдийг энэхүү ажилд татан оруулах ” Хүн бүр нэг мод-нэг сумынхан “ аянг өнөөдрөөс эхлэн өрнүүлцгээе

**“АЖИЛ ХИЙВАЛ ДУУСТАЛ, ДАВС ХИЙВЭЛ УУСТАЛ”**

Тарьсан модоо бие даан ургах хүртэл нь услан, арчлан ургуулах нь мод тарьсан хүн бүрийн үүрэг гэдгийг бүгдээрээ ойлгох ёстой. Модоо дандаа услаж байгаарай хүүхдүүдээ

Олон мод ургах тусам шороо шуурах нь багасна айх аюулгүй сайхан амьдарна.

Энэ төсөлт тоглоомын дараа тус цэцэрлэгт 3 дах жилдээ хэрэгжиж байгаа “Бяцхан цэцэрлэгч” төсөлт тоглоом үргэлжлэнэ, мөн намар 9-11-р сард “Ногооны зах” төсөлт тоглоом үргэлжлэн явагддаг.

Эхийг зохиосон арга зүйч Ц.Туул

Зураач багш А.Рэгзэдмаа, туслах багш Л.Энхсүрэн

Төлөвлөлт боловсруулсан багш Ц.Батчимэг, Л.Наранчимэг